



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

Газрын талбайн хэлбэр, солбицол
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.6, 21.2.7 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/451 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүсэлт ирүүлсэн 2 (Хоёр) иргэний эзэмшиж буй газрын талбайн хэлбэр, солбицолыг хавсралтаар өөрчилсүгэй.

2.Эзэмшиж буй газрын талбайн хэлбэр, солбицол өөрчлөгдөж байгаа иргэдтэй холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/166 дугаар захирамжийн Д.Хасчулуун, 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/202 дугаар захирамжийн Б.Батхуяг нарт хамаарах заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2026 он ажил\захирамж

1226010013